



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/170.

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арвайхээр сумын төв талбайн усан оргилуурт байршуулах загасан хөшөөний зардалд 4,000,000 (дөрвөн сая) төгрөг, тээврийн зардалд 300,000 (гурван зуун мянга) төгрөг, нийт 4,300,000 (дөрвөн сая гурван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100367